



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/116

Хархорин сум

Захирамжийн зарим хэсэгт
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дах заалт, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын "Геодезийн солбицол, өндөр тусгагын нэгдсэн тогтолцоог батлах тухай" 2009 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2013 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын ХХ.1.43-д тусгагдсан "Газрын кадастрын мэдээллийн сан"-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх ажил хэрэгжсэнтэй холбогдуулан хавсралтанд дурдагдсан нэр бүхий 2 иргэний 2 нэгж талбарын өмчилсөн газрын мэдээллийг өөрчилсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжид заасан хүрээнд өмчлөх эрхээ хэрэгжүүлэхийг газар өмчлөгчдөд, иргэний өмчилсөн газрын хил заагийг газар дээр нь тэмдэгжүүлж, хүлээлгэн өгөх, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж, газар өмчлөгчийг хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Ч.Баттулга), (Э.Дэнсмаа) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Г.ОДГЭРЭЛ



401100231